

НҮҮРСГҮЙ ШИЙДЭЛ – МОНГОЛ ГЭРТ ЗОРИУЛСАН ДУЛААЛГА, ХАЛААЛТ, АГААР СЭЛГЭЛТИЙН ЧИП БАГЦ

Төслийн зорилго:


Монгол гэрт зориулсан “Дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП (Cooking, heating and insulation products -CHIP) багц” нэвтрүүлэх төсөл нь ус, салхи нэвтрүүлдэггүй нэмэлт бүрээсээр гэрийг дулаалж, нүүрсээр галладаг уламжлалт зуухыг эрчим хүчиний хэмнэлттэй цахилгаан халаагуураар солин, дотор орчны агаарын чанарыг цогц байдлаар шийдвэрлэснээр эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, өрхийн гишүүдийг тогтмол дулаан орчинд тухтай амьдрах нөхцлөөр хангах, гэрийн дотор болон гадна орчны агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн төсөл юм.

Төслийн хэрэгцээ шаардлага:

Бидний ирээдүй хойч үе болсон хүүхэд, залуус агаар, орчны бохирдол болон түүний сөрөг нөлөөлөлд хамгийн их өртөж, байгаль цаг уурын хүнд ширүүн нөхцөлд өсөн торниж байгаа учраас тэдний эрүүл, аюулгүй нөхцөлд амьдрах үндсэн эрх, суурь хэрэгцээ нь бүрэн хангагдахгүй байна. Агаар, орчны бохирдлыг бууруулахын тулд бодлогын түвшинд ажиллахаас гадна айл өрхөд оновчтой шийдлүүдийг нэвтрүүлж, жижиг алхмаар том өөрчлөлтийг авчрах боломжтой ба үүний нэг нь Монгол гэрт амьдарч буй айл өрхөд зориулсан эрчим хүчиний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй “Дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн бүтээгдэхүүн ЧИП багц” юм. Төслийн хүрээнд тус багцыг 2019 оноос хойш хөгжүүлж, ПИН ОУТББ, ШУТИС болон ToC байгууллагууд хамтран НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгээр орон нутаг болон Улаанбаатар хотод нэвтрүүлээд байна.

Үр шим хүртэгчид:

2024 оны 01-р сарын байдлаар Баянхонгор, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Орхон, Сүхбаатар, Хэнтий аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд амьдардаг 2000 гаруй өрх ЧИП төслийн үр шимийг хүртэж байна.



Зураг 1: Төсөл хэрэгжиж буй байршил, нийт өрхийн тоо

Зорилтот бүлэг:



нэг өдөрт хэмнэсэн хугацаа	48	МИНУТ
2.7 УДАА
3.0 УДАА
17 МИНУТ

Зураг 2: Халаалтын багцыг ашигласнаар хэмнэсэн цаг хугацаа, өдөрт (зураг шинэчилж оруулах - Эх үүсвэр: MMCG report)

НИЙТ ХЭМНЭЛТ

275,000 ТӨГРӨГ

**42,000
ТӨГРӨГ**

Халаалтын
зардлын хэмнэлт

**50,000
ТӨГРӨГ**

Эрүүл мэндийн
зардлын хэмнэлт

**183,750
ТӨГРӨГ**

Өвдсөнөөс үүдэлтэй
орлого алдсаны хэмнэлт

Зураг 3: ЧИП багцыг ашигласнаар хэмнэх халаалтын зардал хүйтний улиралд (зураг шинэчилж оруулах - Эх үүсвэр: MMCG report)

ЧИП нь 3 багцаас бүрддэг:



Халаалтын багц

- Термостат
- Цагийн релей
- Модон шүүгээ
- Цахилгаан халаагур
- Гигрометр
- Дагалдах цахилгаан тоноглол

Дулаалгын багц

- Дулаалгатай өрх
- Хаалганы дулаалга
- Хатавчны дулаалга
- Хормойтой хаявч
- Хормойтой шалавч
- Хөрсний уур тусгаарлагч
- Ус тусгаарлах амьсгалдаг бүрээс
- Уур тусгаарлах дотуур цагаан бүрээс

Агаар сэлгэлтийн багц

- Агаар гаргах нээлхий
- Агаар оруулах нээлхий
- Агаар сорох сэнс
- Тоононы бүрэлт

Зураг 4: багцын зураг

Төслийн үр дүн буюу агаарын бохирдлыг бууруулахад оруулсан хувь нэмэр:

2019-2024 онуудад орон нутгийн төсвээс нийт 6,3 тэрбум төгрөгийг зорилтот бүлгийн өрхүүдэд ЧИП багцыг 50-75%-ийн хөнгөлөлттэй авахад дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд НҮБ-ын Хүүхдийн Сангаас 28 гэр цэцэрлэгт 64 багцыг олгож, 971 хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсөж торниход дэмжлэг үзүүлж байна. Нүүрсийг шатаах явцад их хэмжээний тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, азотын давхар исэл, хүхрийн давхар исэл ялгардаг бөгөөд энэ нь дотор болон гадна орчны бохирдол, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн гол эх үүсвэр болдог. Энэхүү төсөл хэрэгжсэнээр айл өрх, гэр цэцэрлэгт эрчим хүчиний хэмнэлтийг бий болгохоос гадна агаар орчны бохирдлыг бууруулахад шууд хэлбэрээр хувь нэмэр оруулж байгаа билээ.

Нийт 86 өрхийн 126 хүүхдийн дунд (0-5 насны) ЧИП суурилуулахаас өмнөх болон дараах өөрчлөлтийг харьцуулж судлахад тэдгээр хүүхдүүдийн эрүүл мэндэд зэрэг нөлөө гарсан ба ханиад томуу тусах нь багасаж, уушгини хатгалгааны тохиолдол буурсан байна. ЧИП багц нь уламжлалт зуухтай харьцуулахад нярай болон бага насны хүүхдэд илүү ээлтэй бөгөөд халуун зуухнаас үүдэлтэй түлэгдэлт, гэмтэл бэртэлд өртөхгүй, тогтмол дулаан хэмд, тав тухтай, цэвэрхэн амьдрах боломжийг бүрдүүлдэг.

ЧИП багцын үнэ: 3,000,000 төгрөг.

Хугацаа: Уг төсөл 2019 оноос хойш тасралтгүй үргэлжилж байна



7715-2828

